



УВС АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

УВС АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ УРЬДЧИЛСАН ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА

2014/12



Хэрэглэгчдэд зориулсан лавлагаа:

Аймгийн Статистикийн хэлтсээс гаргаж буй дараахь мэдээлэл, танилцуулга, тооллого, түүвэр судалгааны үр дүнг uvs.nso.mn хаягаар орох болон аймгийн ЗДТГ-т байрлуулсан электрон самбарыг ашиглан үзэж, холбогдох мэдээллээ авч болно. Үүнд :

- ✚ Аймгийн нийгэм эдийн засгийн байдлын танилцуулгууд
- ✚ Ажиллах хүчний судалгааны үр дүнгийн танилцуулга
- ✚ Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгааны үр дүн
- ✚ Ажиллагчдын тоо, дундаж цалингийн судалгааны дүн
- ✚ 2010 оны Хүн ам орон сууцны тооллогын үр дүн, сум, багаар
- ✚ Аж ахуйн нэгжийн тооллогын үр дүн, аймгуудаар, сумдаар, 2006, 2011 он
- ✚ 2013 оны ХАА-н салбарын танилцуулга,
- ✚ 2013 оны Хүн ам, өрхийн төлөв байдал сэдэвт танилцуулга
- ✚ 2013 оны Аймгийн үйлдвэр, үйлчилгээний салбарын танилцуулга,
- ✚ 2013 оны Хүн амын ажил эрхлэлтийн танилцуулга
- ✚ Аймгийн ДНБ-ий судалгаа
- ✚ ХАА-н тооллогын үр дүн, 2012 он

Улс, аймгийн мэдээлэл авах хаяг:

uvs.nso.mn
www.uvs.gov.mn

Мэдээллийн сангаас авах бол: www.1212.mn, www.toollogo2010.mn

Увс аймгийн Статистикийн хэлтсийн ажилтнуудтай харилцах хаяг :

uvs@nso.mn / албаны хаяг /
Утас: 70453316, 70452322

АГУУЛГА

Хэрэглэгчдэд лавлагаа	2
Аргачлалын тайлбар	4
III. Хүн ам	
3.1 Хүн ам	5-10
IV Хөдөлмөр	
4.1 Шинэ ажлын байр болон бүртгэлтэй ажилгүйчүүд	10-13
VI. Нийгмийн даатгал,халамж	13-15
VII. Боловсрол	16-18
VIII. Эрүүл мэнд	18-23
X. Соёл	23-24
XI. Байгаль орчин	
11.1 Цаг уурын байдал	24
11.2 Аюулт үзэгдэл, ослын мэдээ	24
XII.Гэмт хэрэг,шүүх	25-26
XIV. Мөнгө,банк,даатгал	27
XV. Төрийн санхүү	
15.1 Орон нутгийн төсвийн орлого	28-30
15.1 Орон нутгийн төсвийн зарлага	30-31
15.1 Төсөвт байгууллагуудын өглөг авалага	31
XVI. Гадаад худалдаа	32
XVII. Үнэ	33-37
XVIII Хөдөө аж ахуй	
18.1 Мал аж ахуй	37-45
18.2 Үр тариа,төмс, хүнсний ногоо тариалалт	45
18.3 Үр тариа, төмс, хүнсний ногоо, байгалийн хадлан бэлтгэлт	46
18.4 <i>Жимс, жимсгээний тариалсан талбай, хураасан ургац</i>	47
18.5 ХАА-н бүтээгдэхүүний үнэ	47-48
XIX Аж үйлдвэр	48-54
XX.Тээвэр холбоо	54-55
XXII. Барилга	55-56

Хүснэгтэн мэдээллүүд

Аймгийн үндсэн үзүүлэлт	57-61
III. Хүн ам	62-67
IV Хөдөлмөр	68-71
VI. Нийгмийн даатгал,халамж	72-74
VII. Боловсрол	74-77
VIII. Эрүүл мэнд	77-80
X. Соёл	80
XI. Байгаль орчин	81
XII.Гэмт хэрэг,шүүх	82-83
XIV. Мөнгө,банк,даатгал	83-86
XV. Төрийн санхүү	87-89
XVI. Гадаад худалдаа	90
XVII. Үнэ	91-92
XVIII Хөдөө аж ахуй	92-113
XIX Аж үйлдвэр	114-116
XX.Тээвэр холбоо	117
XXII.Барилга	117-118
-Ажиллагчдын тоо ,дундаж цалингийн судалгаа	118-120

Аргачлалын тайлбар:**ОРОН НУТГИЙН ТӨСӨВ**

Төсвийн орлого зарлагын тооцоог Олон улсын Валютын сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн гаргаж байна. Төсвийн орлогын мэдээг аймгийн Татварын хэлтэс, төсвийн зарлага, санхүүжилтийн мэдээг СТС-ийн хэлтсээс гаргадаг.

Төсвийн орлогын мэдээг хэрэглэгчдэд илүү тодорхой болгох зорилгоор аймгийн нийт төсвийн орлого, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, орон нутгийн төсвийн орлого, үүнээс улсын төсөвт /аймгийн/ төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт гэж салгаж харууллаа. Төсвийн зарлагыг эдийн засгийн салбарын ангиллаар гаргаж, улсын төсвийн байгууллагууд, орон нутгийн төсвийн байгууллагууд гэж тус тусдаа гарсныг нэгтгэж орууллаа.

ҮНЭ

Аймгийн төвийн хүнсний зах дээр борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал, эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

2012 оноос эхлэн хэрэглээний сагсны нэр төрлийг шинэчилж 213 нэр төрөл болгож 2010 оны 12-р сарын үнээр суурилан ХҮИ-ийг тооцож байна.

АЖ ҮЙЛДВЭР

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдхүүний өсөлтийг гол нэр төрлийн бүтээгдхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Гол нэр төрлийн бүтээгдхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

ХӨДӨЛМӨР

Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, нөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

ЭРҮҮЛ МЭНД

Нялхсын нас баралт (1 хүртэл насны 1000 хүүхдэд ногдох)–ыг тухайн үед 1 хүртэлх насны нас барсан хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

ГЭМТ ХЭРЭГ

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог жилийн дундаж 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно

ХАА-н САЛБАР

Аймгийн ИТХ-ын 2002 оны ээлжит 8-р хуралдаанаар баталсан бүсүүд:

Баруун бүс : Завхан, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Тариалан, Ховд

Хойт бүс : Бөхмөрөн, Давст, Сагил, Түргэн

Зүүн бүс: Зүүнговь, Малчин, Тэс, Хяргас

Өмнөт бүс: Баруунтуруун, Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан

Төвийн бүс : Улаангом хот

ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР :


1. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III , IV, V..... г.м)
I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.
2. Дараахь тэмдэглэлүүдийг ашиглав :
... мэдээлэл байхгүй
0.0 маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй
Д - дахин
3. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.



III ХҮН АМ


2014 онд 2110 эхээс 2127 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрсөн хүүхдийн тоо 128 – ээр буюу 6.4 хувиар өссөн байна.

Гэрийн төрөлт 15 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2 – оор бага байна.



Хүн амын төрөлтийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 7.0 хувиар өссөн байна.


Хүн амын нас баралт 447 гарч өнгөрсөн оны мөн үеэс 9.3 хувиар өссөн бөгөөд 1000 хүнд 6.0 ноогдох болсон нь ноднингийн мөн үеэс 0.5 промилээр өндөр байна. Нийт нас баралтын 17.5 хувийг эмнэлгийн нас баралт эзэлж өнгөрсөн оны мөн үеэс 1.6 пунктээр буурсан байна. Хүн амын нас баралтын тоо өмнөх 4 жилийн дунджаас 4.0 хувиар буурсан байна.



2014 онд 1000 хүн амд ноогдох цэвэр өсөлт 22.5 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.1 промилээр, өмнөх 4 жилийн дунджаас мөн 2.3 промилээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хүн ам, өрхийн мэдээллийн сангаас үндэслэн гаргасан хүн амын тоогоор 2014 оны эцэст 37.9 мянган эрэгтэй, 37.8 мянган эмэгтэй нийт 75.7 мянган хүн байнгын буюу 6 сараас дээш хугацаагаар суурин амьдарч байна. 2013 оноос хүн амын тоо 0.3 хувиар буюу 219 хүнээр өссөн байна.

Бүртгэлээр гарсан хүн амын тоо, сүүлийн 14 жилээр




Баруунтуруун, Завхан, Зүүнговь, Өлгий, Тариалан, Түргэн, Ховд, Цагаанхайрхан, Улаангом сумдын суурин хүн ам өнгөрсөн оноос 0.1-9.4 хувиар өсч, бусад сумдын хүн амын тоо 2.2-10.2 хувиар буурсан байна.



Хүйсийн харьцаа 100.6 хувь, 100 эмэгтэйд 101 эрэгтэй ногдож байна.

Хүн амын 34.6 хувь буюу 26.2 мянга нь аймгийн төв, суурин газарт, 18.9 хувь буюу 14.3 мянга нь сумын төвд, 46.5 хувь буюу 35.2 мянга нь хөдөөд амьдарч байна.

2014 оны хүн амын нас хүйсийн суварга



Хүн амын насыг 2014 оны 12-р сарын 31-тэй харьцуулж бүтэн насаар бодсоноор 33.8 хувийг /25.6 мянга/ 0-14 насны хүүхэд, 60.9 хувийг /46.1 мянга/ хөдөлмөрийн насны хүн ам, 5.3 хувийг /4.0 мянга/ хөдөлмөрийн нас хэтэрсэн хүмүүс эзэлж 2013 онтой харьцуулахад хүүхдийн эзлэх хувь 0.3 пунктээр нэмэгдэж, хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь 0.3 пунктээр буурч, хөдөлмөрийн нас хэтэрсэн хүн амын эзлэх хувь өнгөрсөн оны түвшинд байна.


Хүн амын насыг 2014 оны 12 сарын 31-тэй харьцуулж бүтэн насаар бодсон бөгөөд 70 ба түүнээс дээш насны 1703 өндөр настан, үүний 1063 нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд 100-аас дээш насны 1 хүн, энэ нь 101 настай, эмэгтэй, Улаангом сумын 5-р багт амьдарч байна.

20719 өрх байгаа нь өнгөрсөн оноос 2.3 хувиар буюу 471 өрхөөр өссөн. Нэг өрхөд дунджаар 3.6 хүн амьдарч байна.


3.2 Өрх, өрхийн зарим үзүүлэлт

Бүтэн өнчин хүүхэд 114, хагас өнчин хүүхэд 1538, өрх толгойлсон гэр бүлгүй хүүхэдтэй 3180 хүн байна. Өнгөрсөн хүнтэй харьцуулахад бүтэн өнчин хүүхдийн тоо 1.7 хувиар, хагас өнчин хүүхдийн тоо 3.1 хувиар тус тус буурсан байна.


Бүтэн болон хагас өнчин хүүхдийн тоо, оны эцсээр



Өрх толгойлсон хүний тоо




Өрх толгойлсон эмэгтэйчүүд, хүүхдийн тоогоор, 2014 он



18 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй 2265 өрх байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 3421 хүн бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 5.9 хувиар өсчээ. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүнээс 1502 эмэгтэй байгаа бөгөөд 43.9 хувийг эзэлж байна. Сүүлийн 4 жилийн дунджаас 518 иргэнээр буюу 17.8 хувиар өссөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо




Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 9.5 хувийг 0-14 насны хүүхдүүд, 4.8 хувийг 15-17 насны хүүхдүүд эзэлж байна.

3.3 Төрөлт, нас баралт, цэвэр өсөлт

Иргэний бүртгэлийн мэдээгээр 2014 онд 2152 эхээс 2171 хүүхэд төрсөн байна. Өмнөх оноос төрсөн эхчүүд 4.7 хувиар, амьд төрсөн хүүхдийн тоо 5.0 хувиар тус тус өссөн байна.

461 хүн нас барсан нь өнгөрсөн оноос 27 хүнээр буюу 6.2 хувиар, цэвэр өсөлт 1710 болж 4.6 хувиар тус тус өссөн байна.


Төрөлт, нас баралт, ердийн цэвэр өсөлт, 1000 хүнд ногдохоор, жил бүрийн эцсийн байдлаар



Төрөх үеийн хүйсийн харьцаа 104.2 байгаа нь нийт төрсөн хүүхдийн 51.0 хувийг эрэгтэй хүүхэд, 49.0 хувийг эмэгтэй хүүхэд эзэлж байна. Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн 93.1 хувь нь гэр бүлтэй, 6.9 хувь нь гэр бүлгүй эмэгтэйчүүд эзэлж байна.

Иргэний бүртгэлийн байгууллагын мэдээгээр 2014 онд 2171 хүүхэд төрж, 461 хүн нас барсан, эмнэлэгийн мэдээгээр 2127 хүүхэд төрж, 447 хүн нас барсан байгаа бөгөөд бусад газраас ирж төрсөн, нас барсан хүний тоогоор болон бүртгэл он дамжиж хийгддэгтэй холбоотойгоор зөрүү үүссэн байна.

Гэрлэлт, цуцлалт, онуудаар



Иргэний бүртгэлийн байгууллагын мэдээгээр 2014 онд аймаг нийслэлийн хооронд 1754 иргэн шилжин явж, 516 иргэн бусад аймаг нийслэлээс манай аймагт шилжин ирсэн байна. Манай аймгийн сум хооронд 952 иргэн шилжин явж, шилжин ирсэн бүртгэл хийгдсэн байна. Сум хоорондын шилжих хөдөлгөөний бүртгэл хийгдсэн иргэдийн 61.0 хувь буюу 581 иргэн аймгийн төв болох Улаангом суманд шилжин ирсэн байна.

2014 оны шилжих хөдөлгөөн



IV ХӨДӨЛМӨР


4.1 Шинэ ажлын байр болон бүртгэлтэй ажилгүйчүүд

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 12 дугаар сарын эцэст 1138 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 15.7 хувиар буюу 212 хүнээр буурсан байна.


Аймгийн хэмжээнд 617 эмэгтэй ажил идэвхитэй эрж байгаа нь ажилгүйчүүдийн 54.2 хувийг эзэлж байна.

12 сарын эцсийн байдлаар бүртгүүлсэн, ажил идэвхитэй эрж байгаа ажилгүйчүүдийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 13.1 хувиар буюу 132 ажилгүйчүүдээр өссөн байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 1.1 хувь нь буюу 12 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, сүүлийн 5 жилээр



Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 22.1 хувь нь 15-24 насны, 41.1 хувь нь 25-34 насны, 20.6 хувь нь 35-44 насны, 13.9 хувь нь 45-54 насны, 1.9 хувь нь 55-59 насны 0.4 хувь нь 60 дээш насны ажилгүйчүүд байна. Ажилгүйчүүдийн 29.5 хувь нь дээд, 14.5 хувь нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 50.6 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой, 5.4 хувь нь бага болон боловсролгүй хүмүүс эзэлж байна.




16-аас дээш насны арван мянган хүнд 237 ажилгүйчүүд ноогдож байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 16.8 хувиар буюу 48 хүнээр буурсан байна.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс нь ажилтай байгаа боловч ажил хайгч иргэдийн мэдээллийг бүртгэж эхэлсэн байна. 12 сарын эцэст 633 иргэн бүртгэлтэй ажил хайж байгаа ажилтай иргэн байна.


12-р сарын байдлаар 1624 ажлын байрны захиалга ирсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 34.0 хувиар буурчээ.

Хөдөлмөр



Ажлын байрны захиалга эдийн засгийн ангиллаар авч үзэхэд 16.2 хувийг ХАА, ойн аж ахуй, ан агнуур, 2.2 хувийг уул уурхай, 19.4 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 4.1 хувийг цахилгаан, 0.4 хувийг усан хангамж, 13.6 хувийг барилга, 16.5 хувийг худалдаа, 0.4 хувийг тээвэр, 2.6 хувийг зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ, 0.2 хувийг мэдээлэл, холбоо, 1.2 хувийг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, 0.4 хувийг мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, 3.3 хувийг төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбар, 1.5 хувийг удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 6.3 хувийг боловсролын салбар, 3.3 хувийг хүний эрүүл мэнд, 1.2 хувийг урлаг, үзвэр, тоглоом наадам, 7.1 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар эзэлж байна.

Ажлын байрны захиалга, салбараар , бүтцээр




Ажлын байрны захиалгыг өнгөрсөн 2013 онтой мөн үетэй харьцуулахад цахилгаан эрчим хүчний салбар 6.0 дахин, усны хангамжын салбар 2.0 дахин, бөний болон жижиглэн худалдааны салбар 4.3 дахин, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээний салбар 4.3 дахин, эрүүл мэндийн салбар 3.8 дахин, урлаг, үзвэр, тоглоом наадмын салбар 46.2 хувиар, боловсрол 71.7 хувиар тус тус өссөн байна.

2014 онд 1200 ажлын байр шинээр бий болгох зорилттойгоос 1702 шинэ ажлын байр бий болж зорилтын биелэлт 141.8 хувтай байна.


Шинэ ажлын байранд орсон хүмүүсийн 6.1 хувь нь мэргэжилтэн, 0.6 хувь нь техникч, 1.5 хувь нь контор, үйлчилгээний ажилтан, 21.3 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 23.6 хувь нь ХАА, ой, загас агнуурын ажилтан, 40.2 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлалын ажилтан, 5.1 хувь нь машин механизмын операторч, угсрагч, 1.6 хувь нь энгийн ажил мэргэжил, 0.1 хувь нь зэвсэгт хүчний ажил мэргэжилд ажилд орсон байна.

Ажлын шинэ байранд ажилд орсон хүмүүс, ажил мэргэжлийн ангиллаар, бүтцээр



Шинэ ажлын байранд орсон иргэдийн 25.3 хувийг ХАА, ойн аж ахуй, ан агнуур, 30.9 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 3.5 хувийг цахилгаан эрчим хүчний салбар, 12.5 хувийг барилгын салбар, 15.7 хувийг худалдаа, 2.6 хувийг зочид буудал, зогийн газар, 0.2 хувийг санхүү, 1.0 хувийг төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, 1.6 хувийг эрүүл мэндийн үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбар, 0.2 хувийг боловсрол, 0.2 хувийг тээвэр, холбоо, 6.0 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар тус тус эзэлж байна.

Ажлын шинэ байранд ажилд орсон хүмүүс, салбарын ангилалаар, бүтцээр




Ажлын шинэ байранд орсон иргэдийг өнгөрсөн 2013 онтой харьцуулахад 9.9 хувиар буурсан байна. Өмнөх сараас 219 хүнээр буюу 14.8 хувиар өссөн байна. Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийг өнгөрсөн онтой харьцуулахад барилгын салбар 9.7 дахин, бөөний болон жижиглэн худалдааны салбар 17.9 дахин, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар 3.0 дахин, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээний салбар 2.7 дахин, санхүүгийн салбар 4.0 дахин тус тус өссөн, мөн ажил мэргэжлийн ангилалыг өнгөрсөн онтой харьцуулахад мэргэжилтэн 30.4 хувиар, техникч болон туслах мэргэжилтэн 1.7 дахин, худалдаа үйлчилгээний ажилтан 1.7 дахин, суурин төхөөрөмж, машин механизмын угсрагч 3.9 дахин өссөн байгаа нь зочид буудал, зоогийн газар, худалдаа үйлчилгээний бүтээн байгуулалт ихээр бий болж мэргэжилтэй ажиллах хүчний хэрэгцээ шаардлага ихсэж байгаа нь харагдаж байна.



VI НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

НДС-д шимтгэлээр 16.2 тэрбум төгрөг оруулахаас 13.0 тэрбум төгрөг оруулж төлөвлөгөөг 19.8 хувиар тасаллаа. Өмнөх онтой харьцуулахад НДШ-ийн орлого 718.1 сая төгрөгөөр буюу 5.8 хувиар өссөн байна.


Нийгмийн даатгалын сангийн орлого, тэрбум төгрөг



Сангуудаар авч үзвэл тэтгэврийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 19.4 хувиар, ЭМ – ийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 22.0 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 17.3, ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 20.4 хувиар, ҮОМШӨ-н сангийн орлогын төлөвлөгөө 6.3 хувиар тус тус тасарсан байна.


НДС-ийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг бүх сум 1.0-23.1 хувиар тасалсан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого, төрлөөр, сая төг




Сангуудаар авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэс ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 5.4 хувиар, тэтгэврийн даатгалын сангийн орлого 5.5 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 8.5 хувиар, ҮОМШӨ-н сангийн орлого 10.8 хувиар, ЭМ –ийн даатгалын орлого 4.9 хувиар тус тус өссөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага, төрлөөр, сая.төг



25.0 тэрбум төгрөг тэтгэвэрт, 2.9 тэрбум төгрөг ЭМД-ын санхүүжилтэнд зориулан зарцуулж тэтгэвэр тэтгэмжийг бүрэн олгосон байна.


Нийгмийн даатгалын сангуудын зарцуулалт, бүтцээр, 2014 оны I-XII сар



НДС 126.8 сая төгрөгийн авлагатай байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 77.7 сая төгрөгөөр буюу 2.5 дахин өссөн байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас 1439.7 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 97.4 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 149.3 сая төгрөг, нийтдээ даатгалын сангуудаас 29.5 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд өнгөрсөн оноос 6403.2 сая төгрөгөөр буюу 27.7 хувиар өссөн байна. Нийгмийн халамжийн сангаас 28.3 мянган хүнд 8.2 тэрбум төгрөг зарцуулснаас алдарт эхийн одонгийн тусламж 1.2 тэрбум төгрөг, алдар цолтой ахмадуудад олгосон тусламж 57.3 сая төгрөг, орон нутгийн халамжийн сангаас халамжийн тэтгэвэрт 1850 хүнд 2651.1 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1667 хүнд 1252.6 сая төгрөг, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж 554.8 сая, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 10554 иргэнд үзүүлэх тусламжинд 1107.0 сая төгрөг, жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй 2040 эхчүүдэд 1050,1 сая төгрөгийг хөнгөлөлт болгон тус тус зарцуулсан байна.

Халамжийн сангийн зарцуулалт, сая төгрөг



Асрамжийн газар нийт 20 хүн асруулж байгаагийн 14 эмэгтэй байгаа бөгөөд нийт асруулагчдын 7 нь хүүхэд байна. Асрамжийн үйл ажиллагаанд нийт 343.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Өнгөрсөн оны мөн үеэс асрамжийн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгө 24.3 сая төгрөгөөр өссөн байна.




VII. БОЛОВСРОЛ

Увс аймаг 2014-2015 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 30 сургуулийн 686 бүлэгт 17.0 мянган хүүхэд суралцаж байгаа бүлгийн тоо өнгөрсөн оны мөн үеийн түвшинд, суралцагчдын тоо 2.4 хувиар, өмнөх 5 жилийн дунджаас 8.9 хувиар тус тус буурсан байна.



2014-2015 оны хичээлийн жилд бүрэн дунд боловсролд 3185 хүүхэд, суурь боловсролд 5680 хүүхэд, бага боловсролд 8137 хүүхэд суралцаж байна. Бүрэн дунд боловсролд суралцагчдын тоо өмнөх 4 жилийн дунджаасаа 4.3 хувиар өссөн бол суурь боловсролд суралцагчид 5.7 хувиар, бага боловсролд суралцагчид 12.7 хувиар тус тус буурсан байна.




Шинээр 1-р ангийн 81 бүлэгт 2028 хүүхэд элсэн орсон нь өнгөрсөн оноос 18.6 хувиар, өмнөх 4 жилийн дунджаас 16.6 хувиар тус тус өссөн байна.



Аймгийн ерөнхий боловсролын сургуулиудад 991 үндсэн багш ажиллаж нэг багшид 17 сурагч ноогдож байгаа нь өнгөрсөн оны мөн үеийн түвшинд, өмнөх 4 жилийн дунджаас 2 хүүхдээр буурсан байна.




Сургуулийн өмнөх боловсролд 2014-2015 оны хичээлийн жилд 6588 хүүхэд хамрагдаж өмнөх оноос 0.1 хувиар, өмнөх 5 жилийн дунджаас 12.9 хувиар тус тус өссөн байна.



2014-2015 оны хичээлийн жилд хөдөлмөрийн дээд сургуулийн 1-р курсын өдөр орой, эчнээ ангид 60 оюутан элсэн орж, нийт 208 оюутан суралцаж байна. Хөдөлмөрийн дээд сургуулийн нийт суралцагчдын 66.3 хувь нь буюу 138 эмэгтэй оюутан байна. Хөдөлмөрийн дээд сургуулийг 2014 онд 69 оюутан төгссөн байна.

Улаангом коллежийн мэргэжлийн боловсролын 1-р курсэд 345 хүүхэд элсэн орж нийт, 1372 оюутан суралцаж байна. Үүнээс мэргэжлийн боловсролд нийт 974 суралцагч үүнээс 1 ангид 345 суралцагч, 2 ангид 317 суралцагч, 3 – р ангид 312 суралцагч тус тус суралцаж байна.

Техникийн боловсролд 265 суралцагч үүнээс 2 жилтэй ангид 226, 3 жилтэй ангид 19 суралцаж байгаа бол 1 жилтэй сургалтанд 133 суралцагч суралцаж байна. Улаангом коллежийн нийт суралцагчдын 50.2 хувь буюу 689 эмэгтэй суралцагчид байна. Улаангом коллежийг 2014 онд 490 суралцагчид төгссөн байна.




VIII. ЭРҮҮЛ МЭНД


Аймгийн хэмжээнд 2014 онд нэг хүртэлх насандаа 40 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 6 хүүхдээр өссөн, 1 – 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 9 гарсан бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс 3 хүүхдээр их байна. Жирэмслэлт болон төрөлтийн улмаас эхийн эндэгдэл гараагүй байна.



5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох/ Түргэн /167.0/, Өлгий /167.0/, Сагил /153.8/, Давст /142.9/, Цагаанхайрханд /100.0/, Бөхмөрөн /100.0/, Тариалан /93.0/, Наранбулаг /76.9/, Ховд /55.6/, Тэс /51.3/ суманд байгаа нь аймгийн дунджаас 28.3 – 144.0 промилээр өндөр, Баруунтуруунд 1.3, Улаангом 4.7, Өмнөговь 8.9 промилээр бага бусад суманд гараагүй байна.




0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 40 гарч, 1000 амьд төрөлтөд ноогдох нялхсын эндэгдлийн түвшин 18.8 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.8 промилээр өссөн байна. Өмнөх 4 жилийн дунджаас нялхсын эндэгдлийн түвшин 3.5, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 4.6 промилээр тус тус буурсан байна.



Нялхсын эндэгдэл Өлгий 2, Тариалан 2, Цагаанхайрхан 1, Түргэн 1, Бөхмөрөн 1, Баруунтуруун 1, Өмнөговь 1, Ховд 1, Сагил 1, Улаангомд 29 тохиолдол гарч бусад сумдад гараагүй байна.

Осол гэмтлийн улмаас 63 хүн нас барж, өвчлөгчдийн тоо 781 байна. Осол гэмтлийн улмаас нас барагчдын тоо өмнөх 3 жилийн дунджаас 21.2 хувиар, өвчлөгчдийн тоо 6.4 хувиар тус тус өссөн байна.




Хорт хавдраар өвчлөгчдийн тоо 113 болж, 132 хүн нас барсан байна.




Хорт хавдраар өвчлөгчдийн тоо өмнөх 3 жилийн дунджаас 15.7 хувиар, нас барагчдын тоо 6.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 506 болж өнгөрсөн оны мөн үеэс 1.2 хувиар буюу 6 гаралтаар өссөн байна. 2014 онд гарсан халдварт өвчний тоо өмнөх 4 жилд гарсан халдварт өвчний дунджаас 37.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд 2014 оны жил эцсийн байдлаар,

нийт өвчинд эзлэх хувиар





Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнийг хувиар авч үзвэл гепатит өвчин өмнөх оны мөн үед нийт халдварт өвчний 14.8 хувийг эзэлж байсан бол 2014 оны байдлаар 6.3 пунктээр буурч, салхинцэцэг 7.8 пунктээр, БЗХӨ 4.0 пунктээр тус тус өссөн байна.



10000 хүн тутмаас 68.4 нь халдварт өвчнөөр өвчилж байгаа бөгөөд Түргэн /158.6/, Улаангом /118.7/, Сагил /114.8/, Завхан /88.3/, Тариалан /69.6/ сумдад аймгийн дунджаас 1.2 – 90.2 процедиимиээр дээгүүр, Давст /56.4/, Өмнөговь /50.9/, Наранбулаг /34.0/, Бөхмөрөн /28.5/, Тэс /25.4/, Хяргас /25.0/, Малчин /24.7/, Өлгий /23.7/, Ховд /22.7/, Зүүнхангай /22.5/, Өндөрхангай /22.2/, Зүүнговь /19.1/, /, Баруунтуруун /12.1/, Цагаанхайрхан /10.3/ сумдад аймгийн дунджаас 12.0 – 58.1 процедиимиээр доогуур байна.



Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 8.5 хувь нь гепатит, 50.0 хувь нь БЗХӨ, 12.3 хувь нь сүрьегээр, 3.0 хувь нь гахайн хавдраар, 26.3 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилжээ.



Өнгөрсөн оны мөн үеэс салхинцэцэг 44, трихомониаз 17, цусан суулга 7, хүйтэн 7 гаралтаар тус тус нэмэгдэж, гепатит 31, сүрьеэ 4, гахайн хавдар 25, бруцеллөз 8, тэмбүү 1 гаралтаар тус тус буурсан бол хамуу, мэнэн, мөөгөнцөр, сальмонеллөз өвчин гараагүй байна.



Амбулаториор 325.9 мянган хүнд үзлэг хийгдэж, 19.9 мянган хүн хэвтэн эмчлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс амбулаториор үйлчлүүлсэн хүн 21.0 мянган хүнээр буурсан бол хэвтэн эмчлүүлэгчид өнгөрсөн оны мөн үеэс 0.3 мянган хүнээр өссөн байна.


Хувийн хэвшлийн 12 эмнэлгээр 2014 онд нийт 16.1 мянган хүн үзлэг, эмчилгээ оношлогоо хийлгэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.3 мянган хүнээр их байна. Мөн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний орлого 303.5 сая төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 131.7 сая төгрөгөөр буюу 76.7 хувиар өссөн байна.




Х. СОЁЛ

Аймгийн хөгжимт драмын театр нийт 95.8 мянган хүнд 293 тоглолтоор үйлчилж ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс тоглолтын тоо 18.6 хувиар, үзэгчид 3.0 хувиар тус тус өссөн бол орлого 1.1 хувиар буурсан байна.


Хөгжимт драмын театрын тоглолтын тоо өмнөх 3 жилийн дунджаас 5.7 хувиар, үзэгчид 3.0 хувиар тус тус өссөн байна.



Орон нутгийг судлах музей 4.4 мянган хүнд үйлчилж 2058.0 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс үзэгчид 4.8 хувиар өссөн бол орлого нь 26.3 хувиар буурсан байна. Орон нутгийг судлах музейн орлого өмнөх 3 жилийн дунджаас 4.9 хувиар буурсан бол, үзэгчдийн тоо 16.8 хувиар өссөн байна.



Төв номын сан 4.3 мянган байнгын уншигч, 29.2 мянган ирэгсдэд 40.1 мянган номоор үйлчилсэн байна. Өмнөх оны мөн үеэс уншуулсан ном 5.2 хувиар, уншигчдын тоо 7.5 хувиар тус тус өссөн байна.



XI. БАЙГАЛЬ ОРЧИН

11.1 Цаг уурын байдал

Энэ оны 12-р сард агаарын дундаж температур Наранбулаг, Өндөрхангай, Өлгий, Ховд, Цагаанхайрхан сумдад -19.7 хэмээс доош хүйтэн, бусад сумдад -20 хэмээс дээш хүйтэн байлаа. -30-с дээш хүйтэрсэн хоногийн тоо хамгийн олон нь Зүүнговь суманд 25, Малчин суманд 22, Баруунтуруунд 20 хоног байв. 10 м/сек-ээс их салхитай өдөр Өмнөговьд 9, Цагаанхайрханд 5 хоног байлаа.

Ховд, Өлгий, Наранбулаг, Завхан, Өмнөговь сумууд цасгүй, бусад сумдад 1-11 см цастай байлаа.

Агаарын чанарын мэдээгээр азотын давхар ислийн хүлцэх агууламжаас давсан тохиолдол гараагүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс нүүрс төрөгчийн дутуу исэл 1.03, хүхэрлэг хий 0.006 мг/м³ аар илүү, азотын давхар ислийн хэмжээ 0.005 мг/м³ аар илүү байлаа.

11.2 Аюулт үзэгдэл, ослын мэдээ


Гамшигтай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд: - 2014 оны 12 дугаар сард аймгийн хэмжээнд объектын гал түймрийн 2, мал, амьтны гоц халдварт өвчний 1 тохиодол гарсан байна.

Иргэд унтраасан гал түймрийн тухайд: - Улаангом суманд гарсан 2 удаагийн гал түймрийг иргэд өөрсдөө унтрааж ажилласан.

Мал, амьтны гоц халдварт өвчний мэдээ - Наранбулаг сумын Хужирт багийн нутаг галзуу өвчний улмаас нэг тугал үхсэн байна. Наранбулаг сумын Засаг даргын 2014 оны А/171 дүгээр захирамжаар “Нүцгэн” гэдэг газарт 5 км-ын радиуст тодорхойгүй хугацаагаар хязгаарлалын дэглэм тогтоосон байна.

Газар хөдлөлт бүртгэх “Улаангом” станцад 2014 оны 12 сарын 01-ээс 12 сарын 31- ны хүртэл нийт 331 хөдлөлт бүртгэгдсэн байна. Үүний 36 нь холын, 295 нь ойрын хөдлөлтөөр бүртгэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд болсон 149 хөдлөлтийг сумдаар харуулбал:




Бөхмөрөн, Давст, Сагил Тариалан сумдад хамгийн олон буюу 20-33 хөдлөлт болсон байна.



XII ГЭМТ ХЭРЭГ


Энэ онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 361 болж өнгөрсөн оны мөн үеэс 8.1 хувиар өсч, өмнөх 4 жилийн дунджаас 13 гэмт хэргээр буюу 3.7 хувиар илүү байна.

Гэмт хэргийн гаралт, жил бүрийн эцэст, тоо



Гэмт хэргийн өнгөөр авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэс хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 50.0, дээрмийн гэмт хэрэг 50.0, хүн амын эрүүл мэндийн эсрэг хэрэг 50.0, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 21.4, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг 66.7, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 15.4 хувиар буурч, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 33.3, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 25.2, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 9.1, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 1.4 хувиар, завших үрэгдүүлэх гэмт хэрэг 2, залилангийн гэмт хэрэг 2.1, захиргааны журмын эсрэг гэмт хэрэг 3.5, гэр бүлийн хүчирхийллийн улмаас гарсан гэмт хэрэг 6.2 дахин өссөн байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс нийт хулгайн гэмт хэрэг 12.6 хувиар буурчээ. Энэ онд өмнөх онд гарч байгаагүй аж ахуйн нэгжийн эсрэг гэмт хэргийн 2 тохиолдол гарсан байна.



Нийт гэмт хэргийн дийлэнх нь Улаангом суманд үйлдэгдсэн бөгөөд нийт 193 тохиолдол гарснаас иргэдийн эрх чөлөө эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 86, өмчийн хулгайн 51 тохиолдол гарчээ. Өнгөрсөн оны мөн үеэс Бөхмөрөн, Завхан, Өмнөговь, Өндөрхангай, Тэс, Ховд, Хяргас сумдад гэмт хэргийн гаралт 14.3 - 75.0 хувиар буурсан байна.

Энэ онд 373 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 9.4 хувь буюу 35 нь эмэгтэйчүүд байна. Өнгөрсөн оны мөн үеэс гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн тоо 16.2 хувиар өссөн байна.


Гэмт хэрэгт 18 хүртэл насны 18 хүүхэд холбогджээ. Гэмт хэргийн улмаас 380 иргэд, байгууллагад 730.8 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 27.9 хувиар нэмэгдсэн байна. Иргэд байгууллагад учруулсан нийт хохирлын 72.2 хувийг нөхөн төлүүлжээ.

Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын үед 518.0 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилсэн байна.



Гэмт хэргийн 8.7 хувь нь гудамж талбайд, 31.3 хувь нь согтуугаар, 9.7 хувь нь бүлэглэж үйлдэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бүлэглэж үйлдэгдсэн гэмт хэрэг 6.1, согтуугаар үйлдэгдсэн хэрэг 11.9, гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 33.8 хувиар өсч, гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг 8.6 хувиар буурсан байна.

Шүүхээр 113 гэмт хэрэгт 147 хүн ял шийтгүүлснээс таслуулсан гэмт хэргийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 24.3 хувиар өсч, шийтгүүлсэн хүний тоо 3.9 хувиар буурсан байна. Шүүхээр таслуулсан гэмт хэргийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 4.6, шийтгүүлсэн хүний тоо 18.9 хувиар буурсан байна.



Энэ онд шүүхээр шийтгүүлэгчдийн 2 хувь нь эмэгтэйчүүд, 71.4 хувь нь хорих ялаар тус тус шийтгүүлжээ.



XIV. Мөнгө, банк, даатгал


Монгол банкны эх үүсвэрээр 37.0 тэрбум төгрөг зузаатгалаар авч, 435.7 тэрбум төгрөг гүйлгээнд гаргаснаас 465.0 тэрбум төгрөгийг буюу гаргасан мөнгөний 106.7 хувийг эргүүлэн татсан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зузаатгалаар авсан мөнгө 8.6 тэрбум төгрөгөөр буюу 18.8 хувиар буурсан бол гүйлгээнд гаргасан мөнгө 57.7 тэрбум төгрөг буюу 15.3 хувиар өсч, гүйлгээнээс татсан мөнгө 2.2 тэрбум төгрөг буюу 6.9 хувиар буурсан байна.

Зээлийн өрийн үлдэгдэл 169.4 тэрбум төгрөгт хүрч, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1332.2 сая төгрөг болж ноднингийн мөн үеэс бүх зээлийн үлдэгдэл 38.5 тэрбум төгрөгөөр буюу 29.4 хувиар, хугацаа хэтэрсэн зээл 1056.5 сая төгрөгөөр буюу 4.8 дахин тус тус өссөн байна.

364.8 сая төгрөгийн найдваргүй зээл байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.2 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 247.6 сая төгрөгөөр буюу 3,1 дахин өссөн байна.

Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл өмнөх 3 жилийн дунджаас 77.2 тэрбум төгрөгөөр буюу 1.8 дахин өссөн байна.

■ АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ /Арилжааны банкуудаар, сая төгрөг/





Зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээгээр Хаан, Хас банк тэргүүлж байгаа бөгөөд тэдгээрийн зээлийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 77.1 хувьтай тэнцэж байна.

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.05 хувийг Төрийн банк, Хаан банк 0.17, Хас банк 0.30 хувь, 0.26 хувийг Капитал банкны хугацаа хэтэрсэн зээл тус тус эзэлж байна.


Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 61.0 тэрбум төгрөг болсон байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 17.2 хувиар буюу 9.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Сүүлийн 4 жилийн дунджаас иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 23.4 тэрбум төгрөгөөр буюу 62.4 хувиар өссөн байна.

Хадгаламжийн үлдэгдэл /сая.төгрөгөөр/





Арилжааны банкууд иргэд, аж ахуй нэгж нийт 45.4 мянган зээлдэгчид 163.5 тэрбум төгрөгийн зээлийг олгосон бөгөөд төрлөөр нь авч үзвэл лизингийн зээл 2.6 хувь, хадгаламж барьцаалсан зээл 13.6 хувь, малчны зээл 11.9 хувь, бизнесийн зээл 23.7 хувь, орон сууцны зээл 10.7 хувь, цалингийн зээл 19.1 хувь, тэтгэвэрийн зээл 10.7 хувийг тус тус эзэлж байна. Нийт олгосон зээлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зээлдэгчдийн тоо 37.6 хувиар буурсан бол зээлийн хэмжээ 3.4 хувиар өсчээ байна.



XV ТӨРИЙН САНХҮҮ

15.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцоноор 2014 онд аймгийн төсөвт 17,2 тэрбум төгрөг оруулахаас 17.7 тэрбум төгрөгийн орлого орж төлөвлөгөөний биелэлт 102.7 хувьтай, 2.7 хувиар буюу 469.6 сая төгрөгөөр давж биелсэн байна. Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийн орлого нь өнгөрсөн оны мөн үеэс 2.0 хувиар буюу 345.2 сая төгрөгөөр их байна.

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулалгүйгээр аймаг өөрөө 9.5 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээс 9,7 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 101,9 хувиар биелүүлж, 1.9 хувиар буюу 181,2 сая төгрөгөөр давуулан биелүүлээд байна.

Үүнээс улсын төвлөрсөн төсөвт 2.8 тэрбум төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 2,5 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 89,0 хувиар биелүүлж 11,0 хувиар буюу 311,2 сая төгрөгөөр тасарсан байна. Аймгийн төсөвт өөрийн орлогоор 6.7 тэрбум төгрөгийг

төвлөрүүлэхээс 7.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 107,4 хувиар биелүүлж 7,4 хувиар буюу 492,4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.




Ноднингийн мөн үетэй харьцуулахад аймгийн төвлөрүүлсэн нийт орлого 5.0 хувиар буюу 509.8 сая төгрөгөөр бага, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлсэн орлого 29.4 хувиар буюу 1.1 тэрбум төгрөгөөр бага, харин аймгийн төсөвт төвлөрүүлсэн орлого 8,2 хувиар буюу 541,4 сая төгрөгөөр илүү байна.

2014 онд улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогуудаас аж ахуйн нэгж, байгууллагын орлогын татварын төлөвлөгөө 38.6 хувиар, онцгой албан татварын төлөвлөгөө 55.3 хувиар тасарч нэмэгдсэн өртгийн албан татвар 17,4, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 5,4 хувиар, агаарын бохирдлын төлбөрийн төлөвлөгөө 21,9 хувиар давж биелсэн байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогуудыг нэр төрөл бүрээр нь 0,9 – 57,9 хувиар давуулан биелүүллээ.

Өнгөрсөн 2013 онд төвлөрүүлж байсан орлоготой харьцуулахад авто өөрөө явагч хэрэгслэлийн татвар 0,2, ойгоос хэрэглээний мод түлээ ашигласны төлбөр 38,3, түгээмэл тархацтай ашигт малтмалын бусад нөөц ашигласны төлбөр 63,3, хүү торгуулийн орлого 44,4 хувиар, нэр заагдаагүй бусад орлого 23,0 хувиар тус тус бага байна.

Аймгийн төсвийн орлогын 59.5 хувийг тусламжийн орлогоор, 30.3 хувийг орлогын албан татвараар, 3.0 хувийг татварын бус орлогоор, 4.4 хувийг бусад татвар хураамжаар, 2,9 хувийг өмчийн татвараар бүрдүүлсэн байна.



Ноднингийн мөн үетэй харьцуулахад тусламжийн орлогын эзлэх хувь 2.3 пунктээр буурч орлогын албан татварын эзлэх хувь 2,9 пунктээр нэмэгдсэн байна.



2010 оны мөн үетэй харьцуулахад аймаг өөрөө бүрдүүлсэн орлого 2014 онд 12,5 хувиар их байна.


	2011 I-XII / 2010 I-XII %	2012 I-XII / 2010 I-XII %	2013 I-XII / 2010 I-XII %	2014 I-XII / 2010 I-XII %
Аймгийн төсвийн орлого	112.5	108.8	118.4	112.5
ОНТ-ийн орлого, тусламж	201.5	170.5	315.4	321.7

Аймгийн төсвийн зарлагад өөрөө бүрдүүлсэн орлогын эзлэх хувь 15.5 хувьд хүрч сүүлийн 3 жилийн дунджаас 5,1 пунктээр бага байна.



15.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 62,6 тэрбум төгрөгийн зардал гаргасан нь өнгөрсөн оны мөн үеэс 28.2 хувиар их байна.



Нийт зарлагын 46,1 хувийг цалин хөлсөнд, 5.1 хувийг эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлд, 5,3 хувийг урсгал шилжүүлэгт, 19.2 хувийг бусад зардалд, 11.1 хувийг нийгмийн халамжийн үйлчилгээнд, 13.2 хувийг хөрөнгө оруулалтанд зориулан зарцууллаа.




Өнгөрсөн оны мөн үеэс цалин хөлсний зардлын эзлэх хувь 7.7, эрүүл мэнд, НДШ 0.8 пунктээр бага, хөрөнгө оруулалтын зардлын эзлэх хувь 11.7, урсгал шилжүүлэг 13.2 пунктээр илүү байна.

Төсвийн зардлын 41,2 хувийг төрийн үйлчилгээ, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаанд, 50,0 хувийг боловсрол, соёлын үйл ажиллагаанд, 8,2 хувийг эрүүл мэнд, спортын салбарт зориулан зарцууллаа.


Ноднингийн мөн үетэй харьцуулахад төрийн нийтийн үйлчилгээний салбарт зориулсан зардлын эзлэх хувь 7.2 пунктээр өссөн бол боловсролын салбар 1.9 пунктээр, эрүүл мэндийн салбар 0.6 пунктээр тус тус буурсан байна.

15.3 ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГЛӨГ, АВЛАГА


Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн байгууллагуудын дүнгээр энэ онд 109,0 сая төгрөгийн өртэй, 69,6 сая төгрөгийн авлагатай гарч, өмнөх оны мөн үеэс өглөг 62,7 сая төгрөгөөр буюу 2.3 дахин их, авлага 6.2 сая төгрөгөөр буюу 8.2 хувиар бага байна.



Төсөвт байгууллагын өглөг сүүлийн 3 жилийн дунджаас 16,4 сая төгрөгөөр буюу 78,4 хувиар их, авлага 16,3 сая төгрөгөөр буюу 19,0 хувиар илүү байна.




2014 оны 12-р сарын эцэст байгаа өглөг нь оны эхний 1-р сарынхаас 57,0 хувиар илүү байна.



XVI. ГАДААД ХУДАЛДАА

2014 онд нийт импорт 30407.5 мян.ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 952.6 мян.ам.доллараар буюу 3.0 хувиар буурсан байна. 20.6 мян.тн нефть бүтээгдэхүүн, 99426.9 мян.квт.цаг цахилгаан, 1409 ш мебель тавилга, 1679.2 тн хивэг, 1065.3 тн овъёос, 88 мян.л чацарганы жүүс, жимс жимсгэнэ 70.0 тн, чихэр 4.5 тн, хүнсний ногоо 56.6 тн, өндөг 82.8 мян ш, жигнэмэг 1.5 тн, гоймон 3.9 тн, талх талхан бүтээгдэхүүн 0.3 тн, ундаа жүүс 1.8 мян.л, банз 2457.4 м3, хөц будаа 132.0 тн, битум 686.7, алимны суулгац 1198 ш, интоорын суулгац 2403 ш, чацарганы суулгац 2386 ш, үхэрийн нүдний суулгац 750 ш, улаалзганы суулгац 750 ш, ачааны автомашин 6 ш, суудлын автомашин 5 ш, ус цэвэрлэх төхөөрөмж 6, мотоцикль 1 ш, цаа буга 4 ширхэг тус тус импортоор оруулсан байна.

Нийт импорт, экспорт жил бүрийн эцсээр



Өнгөрсөн оны мөн үеэс авто бензин 9.8, дизель түлш 4.1, цахилгаан 31.0, хуванцар цонх 103.9, овъёос 83.0, битум 51.4, хөц будаа 17.9, хивэг 79.2, банз 172.0 хувиар тус тус өссөн байна.

Ундаа жүүс 88.1, хүнсний ногоо 3.1, гурил 11.0, улаанбуудай 81.6, өндөг 52.4, жигнэмэг 94.1, чихэр 38.4, мебель тавилга 37.5, чацарганы шүүс 72.2, гоймон 40.0, жимс жимсгэнэ 4.1 хувиар тус тус буурсан байна. 2014 оны байдлаар экспортонд 25 ширхэг монгол гэр, 0.3 кг чулуулгын дээж гаргаж нийт экспорт 25.6 мянган ам доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 6.4 хувиар буурлаа.




XVII ҮНЭ

Сар бүрийн 15-21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлэг, сагсны 213 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг судалж сарын инфляци тооцож байдаг. Энэ оны 12-р сарын 15-21 нд судлагдаж буй өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын ерөнхий индекс өнгөрсөн оны мөн үе буюу оны эхнээс 15.2, суурь оноос 55.0, өмнөх сараас 1.1 хувиар өссөн байна.

**ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ,
ТАРИФЫН ИНДЕКС 12-р сарын 21 ний байдлаар**

	2014-12 ^{*100} 2010-12	2014-12 ^{*100} 2013-12	2014-12 ^{*100} 2014-11
ЕРӨНХИЙ ИНДЕКС	155.0	115.2	101.1
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	153.9	114.8	100.6
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	197.4	111.2	100.4
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	184.4	122.8	102.3
04. ОРОН СУУЦ, УС,ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	137.9	105.2	100.9
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	169.4	116.7	101.7
06. ЭМ ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	154.4	121.1	102.6
07. ТЭЭВЭР	127.6	108.5	100.0
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	95.3	99.7	99.7
09. АМРАЛТ,ЧӨЛӨӨТ ЦАГ,СОЁЛЫН БАРАА,ҮЙЛЧИЛГЭЭ	113.7	107.6	100.0
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	201.8	128.4	100.0
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТ.БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	189.8	122.8	104.3
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	181.3	126.7	101.0

Өмнөх сараасаа хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 0.6, согтууруулах ундаа тамхины бүлгийн үнэ 0.4, хувцас бөс бараа гутлын бүлгийн үнэ 2.3, түлш цахилгааны бүлгийн үнэ 0.9, гэр ахуйн тавилга,гэр ахуйн барааны бүлгийн үнэ 1.7, эм тариа эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 2.6, зочид буудал,нийтийн хоолны бүлгийн үнэ 4.3, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 1.0 хувиар өсч, холбооны хэрэгслийн бүлгийн үнэ 0.3 хувиар буурч, бусад бүлгийн үнэ тогтвортой байлаа.




Өмнөх сараасаа 33 бүтээгдэхүүний үнэ 8.6-13333.3 төгрөгөөр өсч, 5 бүтээгдэхүүний үнэ 16-2500 төгрөгөөр буурсан байна.

Гол нэрийн барааны өсөлт, бууралтын хувь

	ӨМНӨХ САРААС	ӨОМҮГ-С
гурил дээд зэрэг	0.0	25.0
гурил, 1-р зэрэг	-9.1	11.1
хонины мах	0.0	3.4
үхрийн мах	0.0	3.4
адууны мах	0.0	10.0
ямааны мах	0.0	0.0
хиам	0.0	19.0
сүү	28.6	14.9
тараг	25.3	16.0
ургамлын тос	0.0	1.9
алим	0.0	30.0
мандарин	0.0	-6.2
төмс	12.5	71.4
байцай	20.0	20.0
лууван	20.0	71.4
манжин	20.0	20.0
Бензин, А-80, 1 литр	0.0	1.2
Бензин, А-92, 1 литр	0.0	2.1
Дизелийн түлш, 1 литр	0.0	1.9


Өнгөрсөн оны мөн үеэс дээд гурил 25.0, 1-р гурил 11.1, үхрийн мах 3.4, хиам 19.0, сүү 14.9, тараг 16.0, ургамлын тос 1.9, алим 30.0, төмс 71.4, байцай 20.0, лууван 71.4, манжин 20.0, бензин, шатахуун 1.2-2.1 хувиар өсч, мандарин 6.2 хувиар буурсан байна.

Өмнөх сараасаа 1-р гурил 9.1 хувиар буурч, сүү 28.6, тараг 25.3, хүнсний ногоо 12.5-20.0 хувиар өссөн байна.



Сүүлийн 5 жилийн 12-р сарыг: - оны эхтэй харьцуулсан индексээс харахад 2014 оны 12 сард хамгийн өндөр буюу 15.2, өмнөх сартай харьцуулсан индексээс харахад 2010 оны 12 сард хамгийн өндөр буюу 4.5 хувийн өсөлттэй байгаагаар тооцогдож байна.

Сарын инфляцийн түвшин



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулснаар барааны бүлгүүдээр үнийн өөрчлөлтийг тооцож үзвэл :


Хүнсний бараа, ундаа ус 14.8 %	Хүнсний бараа, ундаа усны бүлгийн үнэ дүнгээрээ 14.8 хувь өссөн нь талх гурил будааны бүлгийн үнэ 15.6 %, мах махан бүтээгдэхүүний бүлгийн үнэ 5.1, жимс жимсгэний бүлгийн үнэ 21.3, хүнсний ногооны бүлгийн үнэ 32.8, чихрийн бүлгийн үнэ 7.6, сүү сүүн бүтээгдэхүүний бүлгийн үнэ 30.0, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 14.8 хувиар өссөнтэй холбоотой байна.
Согтууруулах ундаа, тамхи 11.2 %	Согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 11.2 % өссөн нь согтууруулах ундааны дэд бүлгийн үнэ 4.1 хувь, тамхины дэд бүлгийн үнэ 18.1 хувь өссөнтэй холбоотой байна.
Хувцас гутал бөс бараа, гутал 22.8 %	Хувцас, гутал, бөс барааны бүлгийн үнэ дүнгээрээ 22.8 хувь өссөн нь хувцас, бөс барааны дэд бүлгийн үнэ 21.3, үүнээс бүх төрлийн хувцасны дэд бүлгийн үнэ 20.0 % , жижиг эдлэл хэрэгслийн дэд бүлгийн үнэ 47.0, гутлын дэд бүлгийн үнэ 26.0 хувь өссөнтэй холбоотой байна.
Орон сууц , ус 5.2 %	Орон сууц, түлш цахилгааны бүлгийн үнэ дүнгээрээ 5.2 хувь өссөн нь орон сууцны түрээс 25.0, орон сууцны засварын үнэ 3.1, цахилгаан болон түлшний бүлгийн үнэ 7.2 хувь өсөнтэй холбоотой байна.
Гэр ахуйн бараа, тавилга 16.7 %	Гэр ахуйн бараа, тавилганы бүлгийн үнэ дүнгээрээ 16.7 хувь өссөн нь гэрийн тавилганы дэд бүлгийн үнэ 9.6 , цахилгаан барааны дэд бүлгийн үнэ 12.3 , гэр ахуйн шилэн эдлэл, сав суулганы барааны дэд бүлгийн үнэ 10.2, оёмол, нэхмэл, эдлэлийн дэд бүлгийн үнэ 25.5, гэр ахуйн цэвэрлэгээний болон бусад жижиг барааны дэд бүлгийн үнэ 22.0, гэр ахуйн зориулалттай хөдөлмөрийн багаж хэрэгслийн бүлгийн үнэ 24.5 хувь өссөнтэй холбоотой байна.

Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 21.1 %	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 21.1 хувь өссөн нь эм тариа эмнэлгийн хэрэгслийн дэд бүлгийн үнэ 19.5, амбулаторийн үйлчилгээний үнэ 17.6 хувиар өссөнтэй холбоотой байна.
Тээвэр 8.5 %	Тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 8.5 хувь өссөн нь хувийн тээврийн хэрэгслийн худалдан авалтын дэд бүлгийн үнэ 14.2, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний дэд бүлгийн үнэ 5.9, тээврийн үйлчилгээний дэд бүлгийн 6.6 хувь өссөнтэй холбоотой байна.
Холбооны үйлчилгээ -0.3 %	Холбооны үйлчилгээний үнэ тарифын бүлгийн үнэ 0.3 хувь буурсан нь гар утасны үнэ 1500 төгрөгөөр буурсантай холбоотой байна.
Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээ 7.6 %	Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээний бүлгийн үнэ 7.6 % өссөн нь кабелийн телевизийн хураамж 5.6 %, биллярд тоглох хөлс 25 %, орон нутгийн сонины захиалгын үнэ 66.7 хувь, үзгэн балны үнэ 2 дахин өссөнтэй холбоотой байна.
Боловсролын үйлчилгээ 28.4 %	Боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 28.4 % өссөн нь их дээд сургуулийн төлбөр 28.4 хувиар өссөнтэй холбоотой байна.
